

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/118/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2022 он	Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр Утас: 70378845 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитор: Г.Батмягмар Утас: 70373089 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Д.БАТЧУЛУУН ТАНАА

Ддд-Дд-11 № 63
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР/



009020040

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	39,727,684.34	35,219,724.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	513,626,775.40	502,143,663.47
	Нийт хөрөнгийн дүн	<u>553,354,459.74</u>	<u>537,363,387.47</u>
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	553,354,459.74	537,363,387.47
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>553,354,459.74</u>	<u>537,363,387.47</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	543,220,129.40	1,180,642,599.50
	Үйл ажиллагааны зардлын дүн	563,871,157.38	1,196,633,671.77
	Үйл ажиллагааны үр дүн	(20,651,027.98)	(15,991,072.27)
	Үйл ажиллагааны бус үр дүн	(3,993.14)	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>(20,655,021.12)</u>	<u>(15,991,072.27)</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	518,949,889.19	553,617,566.86
	Тайлант оны үр дүн	34,544,978.88	(15,991,072.27)
	Эцсийн үлдэгдэл	553,354,459.74	537,363,387.47
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	530,889,109.40	1,172,394,731.50
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	529,274,209.40	1,163,732,031.50
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>1,614,900.00</u>	<u>8,662,700.00</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	<u>(1,614,900.00)</u>	<u>(8,662,700.00)</u>
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	320,262,400.00	315,370,762.00
	Урсгал зардал	320,262,400.00	315,370,762.00
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	320,262,400.00	315,370,762.00
	Улсын төсвөөс санхүүжих	306,838,000.00	305,688,652.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,424,400.00	9,682,110.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

ГХБХБГ нь Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах, засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухайн нэгжийн хилийн цэсийг тодотгох, өөрчлөлт оруулах талаар гарсан саналыг зохих журмын дагуу боловсруулах, газрын кадастр эрхлэх аймгийн Газрын мэдээллийн сан байгуулж, олон нийтэд мэдээллээр үйлчлэх, газрын тайланг зохих журмын дагуу гаргаж Засаг дарга болон ГЗБГЗЗГазарт тайлагнах, нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хийгдэх газар зохион байгуулалтын ажлыг зохион байгуулах, Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлаар гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох, газрын төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулж төр ард түмний хоорондын холбоог бэхжүүлэх, газар ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, газраас үүдэн гарах зөрчил бэрхшээлийг арилгахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилладаг байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 6 дугаар зүйлд заасантай нийцээгүй гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 635,455.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 621,145.0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 14,310.6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн тусламж санхүүжилтийн орлогын өмнөх оны дүн 314,166.6 мянга, тайлант оны дүн 306,838.0 мянган төгрөгийн зөрүүтэй мөн өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх оны үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралтын 140.4 мянган төгрөгийг тусгаагүйг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй байна.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан 14,310.6 мянган төгрөгийн 2 гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” долоо хоногийн дотор мэдээлнэ... гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

(сая төгрөгөөр)

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	635.5	1	621.1	-	-	-	-	1	14.3
2	Төсөл, хөтөлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	ЗГТС	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	ТЕЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ	2	635.5	1	621.1	-	-	-	-	1	14.3